



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2019 оны 04 сарын 26 өдөр

Дугаар А/71

Ховд

Нууц хамгаалах ажилтан томилж,
нэмэгдэл олгох тухай

Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Засгийн газрын 2017 оны 246 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн болон албаны нууц хамгаалах ажилтанд цалингийн нэмэгдэл олгох журам”-ын 1.2, 1.3, 2.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн болон албаны нууц хамгаалах журам өөрчлөгдсөнтэй холбогдуулан аюулгүй байдлын шалгалт, сургалтанд хамрагдсан 1 дүгээр хавсралтанд дурдсан нэр бүхий албан хаагчдыг 2019 оны 3 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн нууц хамгаалах ажилтнаар томилсугай.

2.Төрийн болон албаны нууц хамгаалах ажилтнуудад олгох цалингийн нэмэгдлийн хэмжээг ажлын ачаалал, хариуцаж буй нууцын зэрэглэл, нууцтай ажилласан хугацаа зэргийг харгалзан 2 дугаар хавсралтаар баталсугай.

3.Төрийн болон албаны нууцын тухай хууль, тогтоомжийг сайтар судалж, хэрэгжилтийг нь ханган ажиллахыг нууц хамгаалах ажилтнуудад үүрэг болгосугай.

4.Нууц хамгаалах ажилтнаар томилогдсон албан хаагчдын цалингийн нэмэгдлийг тогтоосон хувь, хэмжээгээр тооцон олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү аж ахуйн тасгийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч /Б.Нямдэлгэр/-д зөвшөөрсүгэй.

5.Энэ тушаал гарсантай холбогдуулж аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2018 оны А/11 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.


ДАРГА



Д.ЭНХБОЛД

2019 ТГ А/71.Сх
02 00330

Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын
2019 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн
А/71 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралт




ТӨРИЙН БОЛОН АЛБАНЫ НУУЦ ХАМГААЛАХ АЖИЛТНААР
ТОМИЛОГДСОН АЛБАН ХААГЧДЫН ЖАГСААЛТ

Д/Д	Албан тушаал	Овог, нэр
1.	Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга	Бямбажав Ганболд
2.	Хууль, эрх зүйн хэлтсийн дарга	Намжил Ганзориг
3.	Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга	Чамейхан Багдал
4.	Цэргийн штабын дарга	Бааст Ганхуяг
5.	Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн гадаад харилцааны асуудал хариуцсан мэргэжилтэн	Буянбат Эрдэнэчимэг
6.	Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн	Дэлгэр Мөнхжагаа
7.	Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн цахим засаглал, мэдээллийн технологи, сүлжээний аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн	Дорж Дөмөгтүшиг
8.	Цэргийн штабын тоо бүртгэл эрхэлсэн офицер	Баасанжав Батмөнх
9.	Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн	Пүрэвжал Цэцэгсүрэн
10.	Архив, бичиг хэргийн эрхлэгч	Пүрэвдорж Долгор
11.	Бичиг хэргийн оператор	Банзрагч Чулуунцэцэг
12.	Бичиг хэргийн оператор	Жанчив Дархижав

-оОо-

Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын
2019 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн
А/71 дүгээр тушаалын 2 дугаар хавсралт



**ТӨРИЙН БОЛОН АЛБАНЫ НУУЦ ХАМГААЛАХ
АЖИЛТНУУДАД ОЛГОХ НЭМЭГДЭЛ**

д/д	Албан тушаал	Овог, нэр	Олгох нэмэгдлийн хэмжээ /үндсэн цалингийн хувиар/
1	Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга	Бямбажав Ганболд	20
2	Хууль, эрх зүйн хэлтсийн дарга	Намжил Ганзориг	20
3	Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга	Чамейхан Багдал	20
4	Цэргийн штабын дарга	Бааст Ганхуяг	20
5	Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн гадаад харилцааны асуудал хариуцсан мэргэжилтэн	Буянбат Эрдэнэчимэг	15
6	Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн	Дэлгэр Мөнхжагаа	20
7	Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн цахим засаглал, мэдээллийн технологи, сүлжээний аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн	Дорж Дөмөгтүшиг	15
8	Цэргийн штабын тоо бүртгэл эрхэлсэн офицер	Баасанжав Батмөнх	20
9	Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн	Пүрэвжал Цэцэгсүрэн	15
10	Архив, бичиг хэргийн эрхлэгч	Пүрэвдорж Долгор	20
11	Бичиг хэргийн оператор	Банзрагч Чулуунцэцэг	20
12	Бичиг хэргийн оператор	Жанчив Дархижав	20

-oOo-